



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ


ОЛОН УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ТӨВ

СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛЬ

ДЭЭД БОЛОВСРОЛЫН
БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ

ЦУВРАЛ
№1

2017 ОНЫ 9 САР



*"Бусадтай адил үзэж харсан
хэдий ч түүний талаар бусдын
тунгааж бодоогүйг эргэцүүлэн
бодож, учир шалтгааныг олж
харахыг судалгаа гэнэ"*



ТӨВЧ АГУУЛГА

Карнегийн сангийн дээд боловсролын асуудал эрхэлсэн комиссоос 1970 онд судалгааны их сургууль гэсэн нэр томъёог эргэлтэнд оруулсан байна. Сүүлийн жилүүдэд манай оронд судалгааны их сургууль байгуулах талаар Дээд боловсролын шинэчлэлийн зураглал, Чанарын шинэчлэлийн бодлого болон Засгийн газрын мөрийн хөтөлбөр зэрэг баримт бичигт тунхаглаж байгаа боловч түүнийг хэрхэн хэрэгжүүлэх, бодлогын хувьд хэрхэн дэмжих талаар тодорхой алхам хийгдэхгүй байна. Тэр ч бүү хэл Азийн шилдэг 100 их сургуульд багтсан нэг биш хэд хэдэн их сургуультай болох зорилго ч тавьж байна. Дэлхийн болон бүс нутгийн шилдэг их сургуулиудад багтах зорилгыг хэрэгжүүлэх

анхны алхам бол судалгааны их сургуультай болох явдал зайлшгүй мөн. Гэхдээ энэ зорилт бол нэг сайхан байшин, кампус барьснаар шийдэгддэг асуудал биш бөгөөд төрөөс сайтар боловсруулсан бодлогын хүрээнд хэрэгжинэ.

Манай төвөөс дээд боловсролын бодлогын өөрчлөлтийн талаар эрхлэн гаргаж байгаа цувралын анхны дугаартаа манай орны хувьд хойш тавьж боломгүй энэ чухал сэдвийг хөндөж, төрийн бодлого боловсруулагчид, их сургуулиудын удирдлагууд, эрдэмтэн багш нарт зориулж санаа авахуйц зөвлөмжүүдийг багтаахыг хичээлээ.

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээс мэдлэгийн үйлдвэрлэлд чиглэж байгаа шилжилт нь дэлхий дахинаа нийгмийн бүхий л салбарт эрс өөрчлөлт авчирч байна. Мэдлэгт суурилсан нийгэмд шилжих үйл явц нь шинжлэх ухаан, технологийн мэдлэгийг бүтээх, түгээх, хэрэглэх чадварыг дээшлүүлэх шаардлагыг улам өндөрт тавих болж байна. Мэдлэг бол эдийн засаг, улс төрийн эрх мэдлийн үндэс болж байна. Дэлхий дахинаа эргэлт буцалтгүй баттай тогтож байгаа мэдлэгийн нийгэмд хөл нийлүүлэн алхаж, мэдлэгийн эдийн засгийн өрсөлдөөнд өөрийн байр сууриа эзлэхийн тулд хөгжиж байгаа орнууд судалгааны их сургууль байгуулахад чухал анхаарал тавьж байна.

Судалгааны их сургууль бол тодорхой чиглэлээр мэдлэгийг бүтээх, түгээх үүрэгтэйн дээр улс орны хөгжилд, ялангуяа хөгжиж буй орнуудын нийгэм-эдийн засгийн хөгжил дэвшилд маш их үүрэг гүйцэтгэдэг. Ийм их сургуулиуд нь харгалзах лаборатори, номын сан бусад дэд бүтэцтэй байж сургалт, судалгаагаа хамгийн өндөр түвшинд явуулах боломжтой болдог. Олон улсын туршлагаас үзэхэд аливаа улсын боловсролын системийн дээд оргил нь судалгааны их сургуулиуд нь байдаг бөгөөд нарийн мэргэжлээр дагнасан цөөн тооны ийм их

сургуулиудтай байдаг. Жишээ нь АНУ-д 4000 гаруй их дээд сургуулиуд байдгаас дөнгөж 200 нь судалгааны их сургууль юм. Их Британид 100 их сургууль, 300 дээд сургуультайгаас 25 нь л судалгааны их сургууль юм. Жижиг улс орнуудын хувьд судалгааны нэг их сургуультай байж болох юм. Гэвч дийлэнх жижиг орнуудад судалгааны их сургууль байдаггүй. Хятад улс 3000 их дээд сургуулиудаасаа 9-ийг нь судалгааны их сургууль болгохоор С9 хэмээх элит их сургуулиудын сүлжээг хөгжүүлж байна. Дээд боловсролын системийг дотор нь тодорхой ангиллаар хувааж хөгжүүлэх нь судалгааны их сургуулийг бий болгоход их тустай байдаг. Тухайлбал, Калифорни муж улсад 3 шатлал бүхий дээд боловсролын системийг муж улсаа хөгжүүлэх Мастер төлөвлөгөөний дагуу бий болгосон нь анхаарал татсан жишээ болж байна.

Дээд боловсролын энэ тогтолцооны оройд нь 10 кампус бүхий Калифорни их сургууль гэсэн судалгааны их сургууль байдаг бол 23 кампус, 433 000 оюутан бүхий Калифорни улсын их сургууль дараах шатлалд нь, 3 сая оюутан бүхий коллежиуд 3 дахь шатлалд нь багтдаг байна. Их дээд сургуулийн эрхэм зорилго, удирдлагын тогтолцоо, санхүүжилтын зарчим нь энэ 3 шатлалд өөр өөр байх бөгөөд муж улсаас тэдгээрт тавих хяналт, дэмжлэг ч бас өөр өөр байдаг байна.



АНУ

НИЙТ ИХ ДЭЭД СУРГУУЛЬ - 4000
СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛЬ - 200



ИБУИНВУ

НИЙТ ИХ СУРГУУЛЬ - 100
НИЙТ ДЭЭД СУРГУУЛЬ - 300
СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛЬ - 25



ХЯТАД

НИЙТ ИХ ДЭЭД СУРГУУЛЬ - 3000
СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛЬ - 9



БАРИМТ 1 - 5:100 ТӨСӨЛ

2000 оны дунд үеэс ОХУ-ын Засгийн газраас дээд боловсролын салбарын үйл ажиллагааг эрс шийдэмгий өөрчлөхөд чиглэсэн арга хэмжээнүүд авсан байна. Үүний үр дүнд 2008 онд Ерөнхийлөгчийн зарлигаар Москвагийн Инженер-физикийн институтэд Үндэсний Цөмийн судалгааны их сургууль, Москвагийн Ган Хайлшийн дээд сургуульд Үндэсний технологийн судалгааны их сургууль гэсэн статус олгосон байна. Харин 2009 онд Засгийн газрын тогтоолоор судалгааны их сургууль шалгаруулах нээлттэй конкурс зарласанд 110 их сургуулийн хүсэлтийг хүлээн авч, 12 их сургуульд ийм статус олгосон бол 2010 онд явуулсан хоёрдахь шалгаруулалтаар 128 их сургуулиас 15 их сургуульд ийм статус нэмж олгосон байна. Ийм статусыг 10 жилийн хугацаатай өгдөг журамтай ажээ. 2005-2008 онд тэргүүлэх их сургуулиудын бүтээлч хөтөлбөрийг дэмжих зорилгоор 30 тэрбум рубль буюу 1 тэрбум долларын хөрөнгө оруулалт хийсэн байна. Үүний үр дүнд их сургуулиуд лабораторийн баазаа шинэчилсэн байна. 2009-2010 онд судалгааны их

сургуулиудыг дэмжих үүднээс 8.42 тэрбум рубль буюу 271.6 сая долларын хөрөнгө оруулалт хийсэн байна. 2012 онд ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путин тэргүүлэх их сургуулиудаа дэмжих зорилгоор зарлиг гаргаж, 5:100 төслийг эхлүүлсэн байна. Энэ төслийн гол зорилго нь дэлхийн хэмжээний чансаа тогтоодог QS, ARWU, THE World системүүдээр Оросын 5 их сургуулийг эхний шилдэг 100 их сургуулийн тоонд багтаахад чиглэж байна. Энэ төсөлд 2015 онд 2 шаттай шалгаруулалт явуулсны дүнд 21 их сургуулийг сонгон шалгаруулж хамруулсан байна. Эдгээр их сургуулиудад 360 000 оюутан суралцаж байгаагийн дээр 21 нобелийн шагналтан ажиллаж байна. 2013-2017 онд эдгээр их сургуулиудад 60.5 тэрбум рубль буюу ойролцоогоор 1 тэрбум долларын дэмжлэг үзүүлсэн байна.

2016 оны QS чансаа тогтоох системээр Оросын 22 их сургууль шилдэг 916 их сургуулийн жагсаалтад багтснаас Москвагийн их сургууль 108-д эрэмблэгдсэн байна. Харин ARWU системээр Москвагийн их сургууль 93-д орсон байна.



БАРИМТ 2 - 211 БА 985 ТӨСӨЛ

1993 оны 2 сард Хятадын удирдлагаас “Боловсролын өөрчлөлт ба хөгжил” гэсэн хөтөлбөрийг гаргаж 100 их сургууль болон зарим нэг мэргэжлийг шинэ зууны эхэн гэхэд дэлхийн түвшинд хүргэх зорилт тавьжээ. 1995 онд Үндэсний гол их сургуулиудад чиглэсэн 211 гэсэн төслийг их сургуулиудын судалгааны ажлын түвшинг дээшлүүлэх, улмаар улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийг бодитой болгох зорилгоор Боловсролын яамнаас санаачилж, улмаар 1996-2000 он хүртэлх ёсдэх таван жилийн төлөвлөгөөнд тусгуулсан байна. 211 гэсэн нь 21-р зуунд 100 тэргүүлэх их сургуультай болох гэсэн зорилтыг тэмдэглэж байна. Хятадын Засгийн газраас 1996-2000 онд 2.2 тэрбум долларын хөрөнгө оруулалтыг тэргүүлэх 10 гаруй их сургуульд оруулжээ. Өнөөдөр 211 гэсэн энэ төслөөс эрдэм шинжилгээ, лаборатори техникийн бааз, хүн хүчний нөөцөд тавьж буй шаардлагыг 117 их сургууль хангасан байна. 1998 оны 5 сарын 4-нд Бээжингийн их сургуулийн 100 жилийн ойн баярын хуралд

Хятадын ерөнхийлөгч Жян Зимин дэлхийн түвшинд хүрсэн цөөн тооны их сургуулиуд бий болгох асуудлыг хөндсөн байна. 1998 оны 5 сард анх зарлагдсан энэхүү төслийг хятадаар он сарыг тэмдэглэх аргаар 985 гэж нэрлэсэн байна. Анх 9 их сургуулийг хамруулсан бөгөөд тэдгээр нь C9 лигийн их сургуулиуд гэж нэрлэгддэг байна. 2004 онд 985 төсөлд хамруулах хоёрдахь шатны шалгаруулалтыг эхлүүлж, өнөөдөр нийтдээ 39 их сургуулийг багтаасан байна. 2011 онд 985 төсөлд нэмж их сургууль оруулахгүй гэж зарласан байна. Хятадын тэргүүлэх C9 их сургуульд Цинхуа их сургууль, Пекин их сургууль, Фудан, Нанжин зэрэг их сургуулиуд багтдаг байна. 985 төсөлд хамрагдсан их сургуулиуд нь 300 саяас 1.8 тэрбум юаны дэмжлэг Засгийн газраасаа авсан байна. Өнөөдөр Цинхуа болон Бээжингийн их сургууль ARWU чансаа тогтоох системээр дэлхийд харгалзан 58, 71-р байрт, QS системээр 24,39-р байрт, THE World системээр 47,42-р байрт орсон байна.





СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1 АВЬЯАС, ОЮУН УХААНЫ ЦӨМ БАЙХ.

Судалгааны их сургууль байгуулах хамгийн гол нөхцөл бол авьяаслаг, оюуны чадавхи бүхий залуучуудыг шилж сонгон оюутнаар элсүүлж, эрдэм шинжилгээний бүтээл туурвилаараа дэлхийд танигдсан эрдэмтэн профессоруудыг урьж ажиллуулж, улс орны “тархи”, оюуны цөм бий болгох явдал юм. Судалгааны их сургууль улс орныхоо оюуны төв болж байгааг тэнд ажиллаж байгаа эрдэмтэд, тухайлбал, нобелийн шагналтны тоо зэрэг үзүүлэлтээр баталгаажуулдаг байна. Ийм их сургуульд элсэлтийн шалгалт нь шударга өрсөлдөөнтэй, бусдын нөлөөгүй явагдаж, хамгийн авьяаслаг гадаад дотоодын оюутныг элсүүлдэг байна. Багш нарын тодорхой хувийг гадаадын эрдэмтдээс бүрдүүлж, эрдэм мэдлэгийн олон улсын сүлжээний

салшгүй нэг хэсэг болсон байх учиртай. Тийм ч учраас өнөөдөр нэртэй эрдэмтдийн хойноос их сургуулиуд хөөцөлдөж, гадаадын авьяаслаг оюутнуудыг татаж элсүүлэх талаар өрсөлдөх болсон байна. Хөгжиж байгаа орнуудын хувьд авьяас чадвартай хүмүүсээ гадагш алдах “оюуны дайжилт” гэсэн үзэгдэл гарч байгаа боловч сүүлийн жилүүдэд гадаадад сурч өндөр мэдлэг чадвар эзэмшсэн хүмүүсээ эх оронд нь буцааж авчрах талаас улс орнууд тодорхой бодлого хэрэгжүүлэх болсон байна. Нөгөө талаас, ажиллах нөхцөл нь хангагдсан байвал эх орондоо ажиллах сэтгэлгээ залуучуудын дунд давамгайлах болсон нь олон орны жишээн дээр харагдаж байна. Судалгааны их сургуулийн өөр нэг үзүүлэлт бол багш оюутны харьцаа байдаг. Ер нь 1 профессор багшид 10-12 оюутан байх нь дундаж үзүүлэлт юм.

2 АКАДЕМИК ЭРХ ЧӨЛӨӨ БА УДИРДЛАГА

Академик эрх чөлөө бол их дээд сургуулиуд тэр тусмаа судалгааны их сургуулийн оршин тогтнох зайлшгүй нэг нөхцөл юм. Судалгааны их сургуулийн засаглалын ерөнхий дүр зургийг харвал удирдлагын тогтолцоо нь улс төрөөс хамааралгүй, бие даасан, академик эрх чөлөөг дээдэлсэн, удирдлагын амин судас нь профессоруудын гарт байдаг, гол шийдвэрүүдийг эрдэмтдийн санал бодолд тулгуурлаж гаргадаг, гагцхүү

мерит зарчимд тулгуурласан сонгон шалгаруулалт, томилгоо хийдэг байна. Судалгааны их сургуулийн бие даасан байдлыг хангахын дээр их сургуулийн хамт олныг хөтлөн авч явж чадах алсын хараатай удирдагч манлайлагчтай байх, амжилтад хүрэх философитой, байнга сурч, өөрчлөгдөж байх орчин уур амьсгалыг бий болгох зэрэг нь чухал ач холбогдолтой болохыг олон улсын жишээ баримт харуулжээ.

3 ХӨРӨНГӨ САНХҮҮЖИЛТИЙН ХАНГАЛТАЙ ЭХ ҮҮСВЭРТЭЙ БАЙХ

Судалгааны их сургууль байгуулах эхний хөрөнгө оруулалтыг гол төлөв төрөөс хариуцдаг. Сүүлийн үед хувийн сектор ч ийм их сургууль байгуулахад хөрөнгө оруулах болж байна. Ийм хөрөнгө оруулалтаар судалгааны гол чиглэлүүдээр орчин үеийн лабораторийн бааз бий болгох, шаардлагатай дэд бүтцийг бүрдүүлдэг байна. Харин судалгааны их сургуулийн үйл ажиллагааны санхүүжүүлэлтийг гол төлөв 4 эх үүсвэрээр хангадаг. Нэгд, төрийн санхүүжилт нь судалгааны их сургуулийн үндсэн үйл ажиллагааг явуулах нөхцлийг бүрэн хангахад чиглэгддэг. Тухайлбал, багш нарын цалин хөлс, тогтмол зардал, суурь судалгааны санхүүжилтэнд хамрагдана. Хоёрдахь эх үүсвэр нь эрдэм шинжилгээний сан, төрийн болон хувийн сектораас эрдэм шинжилгээ, судалгааны ажил, төслийг санхүүжүүлэх хөрөнгөнөөс бүрдэнэ. Гуравдахь эх үүсвэр нь эндаумент буюу тусгай зориулалттай хуримтлалын сан байдаг. Энэ нь их сургуулийн тодорхой үйл ажиллагаа, тухайлбал, шилдэг багшийг урамшуулах шагналын фонд байгуулах, тодорхой судалгааны ажлыг дэмжих, их сургуульд номын сан барих, лаборатори байгуулах зэрэг зорилгоор ивээн тэтгэгчидийн хандивласан хөрөнгө, тэдгээр хөрөнгийн хүүнээс бүрддэг. Сингапурын үндэсний их сургууль 2006 онд 774 сая долларын хөрөнгө хандивлагчдаас

цуглуулж чадсан байна. Санхүүжилтийн дөрөвдэх эх үүсвэр нь юуны өмнө суралцагчдын сургалтын төлбөрөөс бүрдэнэ. Хамгийн нэр хүндтэй, хамгийн сайн эрдэмтэн багштай, орчин үеийн лабораторийн баазтай их сургуульд суралцсанаар төгсөөд хөдөлмөрийн зах зээл дээр эрэлт хэрэгцээтэй мэргэжилтэн болох учраас судалгааны их сургуулийн сургалтын төлбөр бусдаас өндөр байсан ч түүнийг төлөх хүсэлтэй эцэг эхчүүд, оюутнууд олон гардаг. Судалгааны их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил нь үйлдвэрлэлд нэвтэрснээр тодорхой хэмжээний нэмэлт эх үүсвэрийг бий болгоно. Мөн эрдэм шинжилгээний бүтээл, ном, сурах бичгээс орлого орох талтай. Судалгааны их сургуулийн нэг чухал үзүүлэлт нь эрдэм шинжилгээний ажлын санхүүжилтийн хэмжээ, тэр дотроо төрөөс олгож байгаа санхүүжилтийн хэмжээ байдаг. АНУ-ын судалгааны их сургуулиудын эрдэм шинжилгээний ажлын санхүүжүүлэлтийн дээд хэмжээ нь 1.5 тэрбум долларт хүрч байжээ. Харин төрөөс олгож байгаа судалгааны ажлын санхүүжүүлэлт нь 1.1 тэрбумд хүрч байжээ. Түүнээс гадна ивээн тэтгэгчдийн дэмжлэгээр бүрдсэн тусгай зориулалттай хуримтлалын сан, хөрөнгө босгох ажлын хэмжээ зэрэг нь судалгааны их сургуулийг үнэлэх өөр нэг үзүүлэлт болж өгдөг.

4 СУДАЛГАА СУРГАЛТЫН УЯЛДАА ХОЛБОО

Судалгааны их сургуулиуд нь судалгааны ажлыг сургалттай холбоход ихээхэн анхаарал хандуулдаг. Ялангуяа магистр, докторын буюу ахисан түвшний сургалтыг эрдэм судлалын ажилтай нягт уялдаатай явуулдаг. Эрдэм шинжилгээний ажилд магистр, доктор оюутныг оролцуулан, тэдний мэдлэг чадварыг гүнзгийрүүлж, сургалт- эрдэм шинжилгээний ажлын уялдаа холбоог бататгахын дээр ахисан түвшний оюутнуудад сурсан мэдсэнээ амьдрал дээр хэрэглэх

боломжоор хангадаг байна. Түүнээс гадна доктор оюутнууд нь бакалаврын түвшний оюутнуудын семинарын хичээлийг удирдах замаар хүнтэй ажиллах дадлага олж авч, бүтээлч сэтгэхүйгээ хөгжүүлж байдаг байна. Судалгааны их сургуулийн нэг үзүүлэлт бол бэлтгэн гаргаж байгаа магистр, докторын зэрэгтэй мэргэжилтний тоо, тэдгээрийн бүтээл байхын зэрэгцээ төгсөгчдийн ажил эрхлэлт, бүтээл туурвил зэрэг нь чухал үзүүлэлт болж өгдөг.

5 ШИНЖЛЭХ УХААНЫ ХЭЛ

Шинжлэх ухааны хэл дэлхий дахины хөгжлийн үе шат бүрд онцгой үүрэг гүйцэтгэж иржээ. Европын эртний их сургуулиудад шинжлэх ухааны гол хэл нь латин хэл байсан бол Напеолоны үеэс франц хэл ноёрхож эхэлсэн байна. Харин Гумбольдын үзэл санааны дор их сургуулиуд сургалт эрдэм шинжилгээг хослуулах болсон цагаас герман хэлний ач холбогдол өсчээ. Дэлхийн хоёрдугаар дайны дараагаас англи хэл олон улсын тавцан дээр шинжлэх ухааны хэл болж түрэн гарч ирсэн байна. Өнөөдөр араб хэлээр ярьдаг улсууд ч, Хятад ч гэсэн шинжлэх ухааны хэлээрээ англи

хэлийг сонгох болжээ. Ийм нөхцөлд судалгааны их сургуульд англи хэл дээр хичээлээ зааж, эрдмийн бүтээлээ англи хэлээр туурвих шаардлага тавигдах болжээ. Судалгааны их сургуулийг үнэлэх нэг үзүүлэлт бол дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд нийтлүүлсэн бүтээл, түүнээс ишлэл татсан тоо ордог. Иймээс шинжлэх ухааны орчин үеийн хэл болсон англи хэл дээр бүтээлээ туурвиж, олон улсын тусгай шүүлттэй сэтгүүлүүдэд хэвлүүлэх нь судалгааны их сургуулийн нэг үндсэн ажил болох учиртай.

6 ДЭЛХИЙН ТҮВШНИЙ СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛИЙН СОЁЛ, УУР АМЬСГАЛ БҮРДҮҮЛЭХ

Судалгааны их сургууль бол дэлхийн хэмжээний аль ч судалгааны их сургуулиудтай "нэг хэл дээр түвэггүй ярьдаг", "ижил төстэй орчин, уур амьсгал, соёл"-той их сургууль байх ёстой. Ийм соёлыг бүрдүүлэхэд их сургуулийн зүгээс, профессор багш нарын зүгээс ихээхэн хүч чармайлт гаргах ёстой. Их сургуулийн зүгээс судалгааны ажил явуулах нөхцлийг бүрэн хангах, түүний үр дүнг тооцох, эрдмийн ажлын туршлагатай ахмад эрдэмтэн профессоруудыг тэтгэврийн нас үл харгалзан, тэдний эрүүл мэнд, өөрсдийнх нь хүслийг харгалзан их сургуульдаа сургалт, судалгааны ажил эрхлэх боломжоор хангах, гадаадын эрдэмтдийг өөртөө татах нөхцлийг бүрдүүлэх, зөвхөн тухайн хүний авьяас чадвар, туршлага, мэдлэгийг үндэслэн ажилд авах, албан тушаалд дэвшүүлэх, шагнал урамшил олгох,

профессор багш нар болон оюутан сурагчдад авилга, аливаа дарамт шахалт үзүүлэхээс ангид байж, шударга өрсөлдөөн, оюун ухааны уралдааныг хөхүүлэн дэмждэг орчин, соёлыг бий болгох үүрэгтэй. Судалгааны их сургуулийн эрдэмтэн профессорууд нь байнга шинийг эрэлхийлж, судалгааны арга зүйгээ хөгжүүлж, эрдэм шинжилгээний ажлынхаа үр дүнд шинэ онол дэвшүүлж, өөрийн судалгааны ажилдаа шүүмжлэлтэй хандаж, олон улсын нэр хүндтэй сэтгүүлд бүтээлээ тогтмол нийтлүүлдэг байх ёстой. Зохиогчийн эрхийн хэм хэмжээг ягштал баримталж, бусдын бүтээлийг хуулах, зөвшөөрөлгүй ашиглахаас татгалзаж, жинхэнэ шинэлэг бүтээл туурвих үүргийг профессор багш нар хүлээдэг.



МАНАЙ ОРОНД СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛЬ БАЙГУУЛАХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖҮҮД

1 ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦООНД СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛИЙН СТАТУСЫГ ШИНЭЭР ХУУЛЬЧЛАН НЭМЭХ

2002 онд батлагдаж, түүнээс хойш хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт оруулсан Дээд боловсролын хуулийг эргэж харахад дээд боловсролын тогтолцоог их сургууль, дээд сургууль, коллеж гэж ангилсан байна. Харин судалгааны их сургууль гэсэн онцгой статусыг хуульчлаагүй байна. Судалгааны их сургууль нь тухайн улс орны дээд боловсролын тогтолцооны оргилд нь байж өөрийн эрхэм зорилгоо хэрэгжүүлэхэд шаардлагатай дэмжлэгийг төрөөс авдаг байх ёстой.

Өнөөдөр судалгааны их сургууль байгуулахад төр, Засгийн газрын үүрэг роль чухал ач холбогдолтой болжээ. Улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийн ямар чиглэлийг барьж судалгааны их сургуулийг хөгжүүлэх, судалгааны их сургуулийг тогтвортой ажиллаж, жинхэнэ дэлхийн түвшинд хүрсэн судалгааны их сургууль болгоход эрх зүйн болон санхүүгийн бүх талын тусламжийг үзүүлэхэд төр, Засгийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай байдаг.

2 СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛЬ БАЙГУУЛАХ БОДЛОГЫН СОНГОЛТ

Судалгааны их сургууль байгуулж байгаа олон улсын туршлагыг харахад нэгд, одоо байгаа их сургуулийг сонгон шалгаруулж, өргөтгөн хөгжүүлэх, хоёрт, одоо байгаа хэд хэдэн их сургуулийг нэгтгэн шинэ их

сургууль байгуулах, гуравт нь шинээр судалгааны их сургууль байгуулах, эцэст нь судалгааны лабораториудыг байгуулж улмаар судалгааны их сургууль болох үндсийг бүрдүүлэх гэсэн 4 гол арга замыг хэрэгжүүлж байна.

а Одоогоор манайд явж байгаа уур амьсгалыг харахад байгаа хэдэн их сургуулиа судалгааны их сургууль болгох бодолтой хүмүүс давамгайлж байна. Хэдийгээр энэ арга зам бол хямд төсөр боловч нэгэнт тогтсон системийг өөрчлөхөд ихээхэн бэрхшээл тулгардаг байна. 2000 оны үеэс ОХУ болон Хятад улс дээд боловсролынхоо

шинэчлэлийг явуулахдаа тэргүүлэх их сургуулиудаа, тухайлбал, Москвагийн их сургууль, Санкт Питербургийн их сургууль, Бээжингийн их сургууль, Цинхуа их сургуулиудаа онцгойлон анхаарч тусгай статус олгож, маш их хэмжээний хөрөнгө оруулалтыг хийсэн байна.

б Одоо байгаа их сургуулиудыг нэгтгэх арга замаар судалгааны их сургуультай болох хоёрдахь арга зам бол манай нөхцөлд хийх зайлшгүй шаардлагатай алхам бөгөөд сэтгэл зүйн асар их бэрхшээлийг даван туулах шаардлага тулгарна. 3 сая хүн амтай улсад 2-3 жинхэнэ нэр хүндтэй их сургууль байхад хангалттай гэсэн ерөнхий төсөөлөл байдаг. Тэр тусмаа орчин үеийн их сургуулиуд нь сонгодог хэлбэрээр бүх төрлийн

мэргэжлийг багтаасан байдаг онцлогтой учраас Монгол улсын томоохон их сургууль дээр их сургуулиудынхаа оюуны хүчийг төвлөрүүлэхэд болохгүй зүйл байхгүй. 2006-2010 онд ОХУ нэг хот болон тухайн бүс нутагт төвлөрсөн их сургуулиудаа нэгтгэх замаар 10 холбооны их сургууль байгуулсан бол Хятад улс ерээд оны сүүлээр их сургуулиудаа нэгтгэх замаар хүчтэй их сургууль байгуулах ажлыг хийсэн байна.

в Улс орны хөгжлийн тэргүүлэх чиглэлд дорвитой хувь нэмэр оруулах боломжтой бөгөөд гадаадын эрдэмтэд, оюутны сонирхлыг татах чиглэлүүдийг хамарсан авсаархан хэмжээний судалгааны цоо шинэ их сургууль байгуулж болох юм. Хэдийгээр ийм их сургууль байгуулахад хөрөнгө ихээр шаардагдах боловч богино хугацаанд олон улсын түвшинд хүрсэн судалгааны их сургуультай болох боломж бүрдэнэ. Цоо шинээр судалгааны их сургууль байгуулахад ойролцоогоор 500 сая долларын хөрөнгө оруулалт хэрэгтэй гэж америкийн эрдэмтэд тооцоолсон байна. Саудын

Араб улс 2009 онд Шинжлэх ухаан технологийн их сургуулийг 3 тэрбум доллараар байгуулж, богинохон хугацаанд ихээхэн анхаарал татаж байгаа ирээдүйтэй судалгааны их сургуультай болсон байна. Манай орны хувьд геологи, археологи, түүх, монгол судлал, мал аж ахуй, биологи, биотехнологи, мэдээллийн технологи зэрэг мэргэжлээр олон улсын хэмжээнд ажиллаж байгаа цөөн тооны эрдэмтэд, судлаачид байна. Мөн гадаадад эрдмийн ажил хийж, мастер докторын зэрэг хамгаалсан залуучууд ч олон болж байна. Тэдний оюуны хүчийг нэгтгэж цоо шинэ их сургууль байгуулах боломж манайд бий.

с Зарим улс орнууд судалгааны их сургууль байгуулах үндэс суурийг тавихын тулд их сургуулийн бүрэлдүүнд бие даасан center of excellence байгуулж ажиллуулж байна. Ийм төвийг улсаас нийгэм эдийн засгийн

тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх зорилгоор байгуулж, санхүүжилтийн хангалттай эх үүсвэрээр 5-10 жилийн турш хангаж, үр дүнд хүрч байгаа жишээг Өмнөд Солонгос болон бусад улсын жишээн дээр харж болно. Өмнөд Солонгосын Кванжу хотноо 1993 онд Шинжлэх



ухаан, Технологийн их сургууль байгуулж, түүндээ шинэ технологийн төв байгуулж 9 жилийн турш жил бүр 1 сая долларын санхүүжилт хийж, судалгааны их сургууль болох зорилтыг тавьж байсан бол өнөөдөр Кванжу хотын Шинжлэх ухаан, технологийн их сургууль чансаа тогтоох THE системээр дэлхийн шилдэг 300 их сургуулийн тоонд багтсан байна. Түүнээс гадна интернетэд суурилсан виртуаль төвүүдийг байгуулж ажиллуулах болжээ. Өөр улс орнуудад нэг сэдвээр ажиллаж байгаа эрдэмтдийн виртуаль сүлжээ

байгуулах замаар хамтарсан судалгааны ажлыг явуулах болж байна. Эцэст нь дийлэнх улс орнуудад тогтсон Шинжлэх ухааны академи, олон улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг Олон улсын Шинжлэх ухааны зөвлөл (ISCU), Олон улсын Нийгмийн Шинжлэх ухааны зөвлөл (ICSS), Хөгжиж буй орнуудын Шинжлэх ухааны академи (TWAS) зэрэг байгууллагуудтай холбоотой ажиллаж хамтарсан судалгааны ажлыг явуулах замаар судалгааны их сургуулийн суурийг бүрдүүлж болно.

БАРИМТ 3 - ХАМГИЙН ХУРДАН ДЭЛХИЙН ШИЛДЭГТ ОРСОН СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛЬ

2009 онд Абдулла хааны нэрэмжит Шинжлэх ухаан, технологийн их сургуулийг Саудын Арабын Тувал хотноо байгуулсан байна. Энэ судалгааны их сургууль нь дэлхийн түвшний судалгаа явуулахын дээр зөвхөн ахисан түвшний сургалттай ажээ. 2016 оны байдлаар тус сургуульд дэлхийн 60 орны 940 оюутан сурч байсан бөгөөд 1200 төгсөгчидтэй болсон байжээ. Нийт оюутны 69%-нь гадаадын оюутан бөгөөд нийт оюутны 83%-нь докторын зэрэг олгох сургалтанд хамрагдаж байна. Нийтдээ 150 орчим профессор багштай байгаа бөгөөд цаашдаа профессор багшийн тоог 220 –д хүргэх төлөвлөгөөтэй ажээ. Тус их сургуульд орчин үеийн Шахиин 2 гэсэн дэлхийд

15-д ордог суперкомпьютерийн лаборатори, аналитик химийн хроматограф, спектроскоп, масс спектрометр зэрэг лабораторийн төхөөрөмжтэй, биологийн чиглэлийн ДНК-ийн болон эд эсийн шинжилгээний нарийн багаж төхөөрөмж бүхий лаборатори байгуулсан байна. Энэ их сургууль судалгааны ажлынхаа үр дүн, эрдэм шинжилгээний бүтээлийн ишлэл таталтаар хамгийн хурдан өсөж байгаа их сургууль гэж 2013 онд зарлагдсан бөгөөд 2015 оны QS чансаа тогтоох системээр нэг багшид ногдох бүтээлийн ишлэл таталтаар дэлхийн шилдэг их сургуульд эрэмблэгдсэн байна. Энэ их сургуульд манай зарим судлаачид ажилладаг мэдээ байна.

ХОЛБОГДОХ ЭХ СУРВАЛЖУУД

Philip G.Altbach, Jamil Salmi. The Road to Academic Excellence. The Making of World-Class Research Universities. World Bank, 2011.
 The future of research universities. EMBO report. 2007. 8(9).
 J. Cole. The triumph of America’s Research University. The Atlantic. 2016
 Public Research Universities: Why they matter? American Academy of Arts and Sciences. 2015
 Н.Р.Тойвонен, В.Н. Васильев. Исследовательский и/или предпринимательский. Какие университеты создаются в России? Образование и инновации. №5 май 2010.
 И.Г.Салимьянова. Роль исследовательских университетов в развитии национальной инновационной системы. Общество. Среда. Развитие. 2011. №4 с.1519
 Kunlun Ngok, Weiqing Guo. The quest for World class universities in China: critical reflections. Policy Futures in Education. Vol 6 Number 5 2008

SUMMARY

This edition of the policy briefs explains need for Research University in Mongolia and gives brief analysis of research university development and key characteristics of the research universities. Research universities share five common characteristics - a high concentration of talented academics and students, significant budgets, academic freedom, autonomy and leadership, research and teaching nexus, research culture and the language of science. The recent development in creating research universities in Russia, China and Saudi Arabia showcased in this brief. Research universities thrive in environments that foster competitiveness, unrestrained scientific inquiry and academic freedom, merit-based enrollment

and promotion, critical thinking, innovation and creativity. The policy brief provides a set of policy recommendations and policy choice for creating Research University in Mongolia which targets policy makers, researchers and university leaders.

The International Center for Higher Education Research of the Mongolian University of Science and Technology presents research-based information in a brief and concise format targeted policy makers and researchers. Readers are encouraged to make reference to the briefs or the underlying research publications in their own publications.



ШУТИС-ИЙН ОЛОН УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ТӨВ

Тус төв энэ хичээлийн жилээс сар бүр дээд боловсролын тулгамдсан асуудлаар “Дээд боловсролын бодлогын өөрчлөлт” цувралыг хэвлэж гарган, мөн ШУТИС-ийн веб хуудсаар түгээх болно. Эдгээр цуврал нь дээд боловсролын бодлого боловсруулагчид, эрдэмтэн судлаачдад зориулагдсан бөгөөд энэ цувралын материалыг ашиглах, өөрсдийн судалгаанд ишлэл татан хэрэглэхийг бүрэн дэмжиж, Creative Commons нээлттэй лицензээр зохиогчийн эрхээ баталгаажуулсан.



Судалгааны баг

Доктор, профессор Д.Бадарч

Доктор, профессор Б.Очирбат

Доктор, дэд профессор Т.Намнан

Судлаач Б.Мөнххүж

Хянан тохиолдуулсан: Б.Очирбат

